

**“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС” - ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

**“Люкс Занаду Групп” ХК**

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10		83%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	7		70%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6		100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	4		67%
5	Эрсдэлийн удирдлага	8	5		63%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6		100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	6		75%
8	Компанийн соёл	6	6		100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10		100%
	<b>Нэгдсэн дүн</b>	<b>72</b>	<b>60</b>		<b>83%</b>

“Люкс Занаду Групп” ХК нь Монголын Хөрөнгийн биржийн бүртгэлтэй ХК-иудад зориулсан “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний асуулга”-ыг ашиглан үндсэн есөн үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн болно. Нэгдсэн дүнгээс харахад “Люкс Занаду Групп” ХК-ийн засаглалын нэгдсэн үнэлгээ нь 94 хувьтай буюу засаглал хэвийн түвшинд гэж үнэлэгдэж байна.

**Үнэлгээний асуулга**

НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Хэрэгжсэн		2	100%
1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Зөвхөн ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгасан байдаг	1	50%
1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна	Хэрэгжсэн	Хөрөнгийн биржийн цахим хуудас болон өөрийн компанийн цахим хуудсанд мэдээлэл байршуулдаг.	2	100%
1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлагыг авч үздэг ч хүйсийн тэнцвэрт байдлыг тусгадаггүй	1	50%
1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Хэрэгжсэн	ТУЗ-н дарга болон Гүйцэтгэх захиралын чиглүүлэх сургалт явагддаг	2	100%
1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Хэрэгжсэн		2	100%
<b>ДҮН</b>			10	83%
<b>ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ</b>				

	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 1/3 нь хараат бус гишүүн байхаар сонгосон байгаа	1	50%
	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Хэрэгжсэн	Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд зааснаар ТУЗ-ийн Аудитын хороон даргаар Хараат бус гишүүн ажиллаж байгаа бөгөөд ТУЗ-дарга бус байдаг	2	100%
	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Хэрэгжсэн	Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд зааснаар ТУЗ-ийн Аудитын хороон даргаар Хараат бус гишүүн ажиллаж байгаа бөгөөд ТУЗ-дарга бус байдаг	2	100%
	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд зааснаар ТУЗ-ийн Аудитын хороон даргаар Хараат бус гишүүн ажиллаж байгаа бөгөөд ТУЗ-дарга бус байдаг	1	50%
	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн		1	50%
<b>ДҮН</b>				<b>7</b>	<b>70%</b>
<b>ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ</b>					
	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина	Хэрэгжсэн	Компанийн албан ёсны цахим хуудас, Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас нээлттэй тайлагнадаг.	2	100%
	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Хэрэгжсэн	Компанийн албан ёсны цахим хуудас, Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас нээлттэй тайлагнадаг.	2	100%
	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна	Хэрэгжсэн	Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг олон нийтэд нээлттэй байршуулдаг	2	100%
<b>ДҮН</b>				<b>6</b>	<b>100%</b>
<b>ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО</b>					
	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Хэрэгжсэн	Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд зааснаар ТУЗ-ийн Аудитын хороо хөндлөнгийн аудитыг сонгох боломж нээлттэй байдаг.	2	100%

4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	хөндлөнгийн аудит оролцох нь нээлттэй байдаг.	1	50%
4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Олон нийтэд нээлттэй мэдээллэнэ	1	50%
<b>ДҮН</b>			<b>4</b>	<b>67%</b>
<b>ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА</b>				
5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн		1	50%
5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Эрсдэлийн хороо байхгүй, Гүйцэтгэх захиралын үйл ажиллагаанд хамаарч байгаа	1	50%
5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Хэрэгжсэн	Үйл ажиллагааны тайланд тусгагдсан	2	100%
5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн		1	50%
<b>ДҮН</b>			<b>5</b>	<b>63%</b>
<b>ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ</b>				
6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална	хэрэгжсэн	ХЭХ болон үйл ажиллагааны тайланд тусгадаг	2	100%
6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	хэрэгжсэн	ХЭХ болон үйл ажиллагааны тайланд тусгадаг	2	100%
6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	хэрэгжсэн	ХЭХ болон үйл ажиллагааны тайланд тусгадаг	2	100%
<b>ДҮН</b>			<b>6</b>	<b>100%</b>
<b>ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ</b>				
7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Байгууллагын соёлыг төлөвшүүлэх ажил хийгдэж байгаа ч бодлогын баримт бичгийг бүрэн боловсруулаагүй байна	1	50%
7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана	хэрэгжсэн	Үйл ажиллагааны тайланд тусгадаг	2	100%

7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	хэрэгжсэн	Тухай бүрт мэдээллийг олон нийтэд танилцуулдаг	2	100%
7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Зорилтот ажил хийгдэж байгаа ч бодлогын баримт бичгийг бүрэн боловсруулаагүй байна	1	50%
<b>ДҮН</b>			<b>6</b>	<b>75%</b>
<b>НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ</b>				
8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	хэрэгжсэн	Үйл ажиллагааны тайланд тусгадаг	2	100%
8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.	хэрэгжсэн	Компанийн хурал бүр дээр ажилчдад мэдээлэл өгдөг	2	100%
8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	хэрэгжсэн	Компанийн хурал бүр дээр ажилчдад мэдээлэл өгдөг	2	100%
<b>ДҮН</b>			<b>6</b>	<b>100%</b>
<b>ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ</b>				
9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	хэрэгжсэн	Тухай бүрт мэдээллийг олон нийтэд танилцуулдаг	2	100%
9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	хэрэгжсэн	Тухай бүрт мэдээллийг олон нийтэд танилцуулдаг	2	100%
9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	хэрэгжсэн	Тухай бүрт мэдээллийг олон нийтэд танилцуулдаг	2	100%
9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна	хэрэгжсэн	Тухай бүрт мэдээллийг олон нийтэд танилцуулдаг	2	100%
9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	хэрэгжсэн	Тухай бүрт мэдээллийг олон нийтэд танилцуулдаг	2	100%
<b>ДҮН</b>			<b>10</b>	<b>100%</b>
<b>Нэгдсэн дүн</b>			<b>60</b>	<b>83%</b>